

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Номгон Гүйцэтгэлийн гэлийн хувь |
|-----|--|-------|---------------------------------------|--------------|-----------------|-----------|--|---|---------------------------------|
| | | | | | Хагас жил | Бүтэн жил | 8 | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | |
| 1 | Зорилт 1. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын талаар төрөөс баримтлах бодлого, шийдвэрийг хангах зорилтын хүрээнд: | | | | | | | | |
| 1.1 | Төсөл хөтөлбөрүүдийг судалж гадаад харилцааг идэвхжүүлэх оновчтой хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах | - | Хэрэгжүүлсэн төслийн тоо | 3 | 3 | 4 | Гадаад харилцааны яамны Олон улсын хамтын ажиллагааны газарт сум, байгууллагуудаас ирүүлсэн 21 төслийн саналыг хүргүүлэн ажиллаж, Хүүхдийг ивээх сан Япон улсын Гадаад хэргийн яамны санхүүжилтээр "Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь" төсөл Баянхонгор аймагт 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 3 жилийн хугацаанд хэрэгжихээр болов. Тайлант онд хөдөө аж ахуй, байгаль орчин, хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, боловсролын салбарын 7 төсөл хөтөлбөр Баянхонгор аймагт хэрэгжиж байна. | 100% | |
| 1.2 | Монгол Улсын гадаад бодлогод нийцүүлэн Холбооны гишүүн харилцаа орнуудтай улам холбоогоо өргөжүүлэх, хамтран төсөл хэрэгжүүлэх, худалдаа эдийн засгийн харилцааг шинэ түвшинд хүргэх | - | Хэрэгжүүлсэн аргачлалын хэмжээний тоо | 1 | 1 | 2 | -Унгар улсын Веспрем хоттой эдийн засгийн хөгжил, хөдөө аж ахуй, боловсрол, аялал жуулчлал, соёлын солилцоо чиглэлээр "Хамтран ажиллах гэрээ" байгуулж, Баянхонгор аймагаас ажиллах хүч ажиллуулах, оюутан сургах асуудлаар санал гарган талууд зөвшилцөлд хүрэв. -ЕБС-ийн 9 сурагчийг БНХАУ-д соёлын солилцооны хөтөлбөрт хамруулж, орон нутгийн соёлыг сурталчилж ажилласан. | 100% | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | <p>-Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачлагын хүрээнд Баянхонгор аймгийн цөлжилтийг сааруулах зорилгоор БНХАУ-ын Ниншя Хуй-ӨЗО-д "Цөлжилттэй тэмцэх арга аргачлал" танхим, практик хосолсон 7 хоногийн сургалтад байгаль орчны чиглэлийн 14 албан хаагчийг хамруулж, чадавхжуулсан.</p> <p>-Хунан мужид зохион байгуулагдсан экологийн соёл иргэншил болон аялал жуулчлалын хөгжлийн нөөцийн тогтвортой хөгжлийн туршлагаас хуваалцах "Байгальд ээлтэй хөгжил" сэдэвт хуралд аймгийн ЗДТГ-ын Байгаль орчин уул уурхай, газрын асуудал хариуцсан мэргэжилтэн, Байгаль орчны газрын дарга нар оролцсон. Тухайн онд байгаль орчны салбарын албан хаагчдыг гадаадад туршлага судлуулах ажлыг өмнөх онуудтай харьцуулахад өргөн хцэр хүрээтэй зохион байгуулсан бөгөөд сургалтаас олж авсан мэдлэг, туршлагаа хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, бусад бодлогын баримт бичгүүдэд байгаль орчин, ногоон байгууламж, цөлжилтийн эсрэг хэрэгжүүлэх саналуудаа тусгасан байна. Эрдэнэ монгол ХХК Шинэжинст сумын нутаг дэвсгэрт 1 га газарт элсний нүүдлийг сааруулах зорилгоор дөрвөлжин тарималалтын аргаар мод тарих туршилтыг хийхээр төсөв хөрөнгийг шийдүүлсэн байна.</p> <p>-Канад Улсын Бритиш Колумбиагийн их сургуулийн профессор, Лаурел сангийн Монгол дахь төслийн зохицуулагч, Доктор</p> | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|-----|---|---|-------------------|----|----|-----|---|------|
| 1.3 | Төрийн албанд ёс зүй, чадахуйн зармыг төлөвшүүлж, үйл ажиллагааны чанар хүртээмж, ил тод байдлыг сайжруулах | | Хэрэгжилтийн хувь | 60 | 80 | 100 | <p>Хью Парсонсоор ахлуулсан ажлын хэсэг манай аймагт ажиллаж, айлчлалын үр дүнд Баянхонгор аймгийн аймгийн 20 суманд Канад улсын Лаурел сан, Эрдэнэ ресурс, Эрүүл мэндийн яамтай хамтран нүдний өвчний эрт илрүүлэг, нүдний эмгэгээс урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн мэдлэг, дадал олгох цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр болсон.</p> <p>-Япон Улсын эрдэмтэдтэй хамтран Монгол орны хөрс, цаг уурт тохирсон шингэн бордоог үйлдвэрлэхээр Баянхонгор аймгийн Өлзийт-ХАА МСҮТ-тэй хамтран судалгаа, үйлдвэрлэлийн туршилтын ажил эхэлсэн.</p> <p>-Төр, хувийн хэвшлийн 13 мэргэжилтэн байгаль орчин, хөдөө аж ахуйн чиглэлээр Ганьсу мужид 8-20 хоногийн сургалтад хамрагдаж тухайн орон нутгийн цөлжилттэй тэмцсэн болон өвлийн хүлэмжийн аж ахуйг эрхлэх арга туршлагатай танилцаж, мэдлэг туршлага хуримтлуулсан.</p> <p>-БНХАУ-ын Гансу мужид 10 оюутныг инженерийн чиглэлээр элсүүлж, сургаж байна.</p> <p>-ХААИС-ын Баянхонгор аймаг дахь салбар сургуулийн багш, ажилтан, оюутан 15 хүний баг Ганьсу мужийн Жичюань хотын коллежид туршлага судлаад ирсэн.</p> | 100% |
| | | | | | | | Аймгийн албан ёсны baauihongo.gov.mn цахим хуудсанд төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт, албан тушаалын сул орон тооны зарлал, төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэх тухай зар болон төрийн албаны тусгай шалгалтын | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|-----|--|---|-------------------|----|----|-----|---|------|
| 1.4 | Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах | | Хэрэгжилтийн хувь | 60 | 80 | 100 | <p>талаар нийт 35 мэдээллийг цахим хуудас болон "Нээлттэй засаг-Нэг Баянхонгор" фэйсбүүк пэйж хуудсанд тухай бүр нээлттэй байршуулж, олон нийтэд хүргэсэн.</p> <p>Төрийн захиргааны албан тушаалд шинээр томилогдсон алба хаагчдад холбогдох хууль, дүрэм журам, тогтоол болон байгууллагын дотоод журам, хамтын гэрээг танилцуулах зорилгоор шинэ албан хаагчдын танилцах хавтсыг үүсгэсэн. Тайлант онд шинээр томилогдсон 8 алба хаагчид байгууллагын болон бусад холбогдох дүрэм журмыг танилцуулж, албан хаагчид ёс зүйн зөрчилгүй ажилсан. Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хорооноос Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг танилцуулж, мэдлэг олгох сургалтыг 2023 оноос хойш шинээр томилогдсон болон нийтлэг үйлчилгээний 25 албан хаагчдад 2 удаа сургалтад хамруулсан. Ёс зүйн дэд хорооны гишүүн, Гадаад харилцааны асуудал хариуцсан мэргэжилтэн С.Лхамхоролтой хамтран "Дипломат ёс-Ажил хэрэгч соёл" сэдэвт сургалтыг, Насан туршийн суралцахуйн төвийн багш Б. Мөнхнасантай хамтран "Хүмүүс хоорондын харилцааны чадвар" багц сургалтад байгууллагын нийт алба хаагчдыг хамруулсан. Мөн шинээр томилогдсон алба хаагчийг дадлагажуулах дэд хөтөлбөрийг боловсруулж, Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн А/105 дугаар</p> | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|-----|---|---------|---|-----|------|------|---|------|
| | | | | | | | тушаалаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | |
| 2 | Зорилт 2.Төрийн удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, боловсон хүчний бодлогыг хэрэгжүүлэх: | | | | | | | |
| 2.1 | Аймгийн хэмжээний ТАХ-ын нийгмийн баталгаа хангах хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг хангах | - | Хөтөлбөр батлуулсан байх, хэрэгжилтийн хувь | 0% | 100% | 100% | Аймгийн хэмжээний төрийн албан хаагчдын сургалт нийгмийн баталгааг хангах стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулах саналыг Засаг даргын 2004-2008 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан. Төлөвлөгөөний суурь судалгаанууд хийгдэж боловсруулалтын шатандаа явж байна. | 70% |
| 2.2 | Төрийн болон аймгийн шагналд тодорхойлолт ирүүлсэн иргэдийн материалд хяналт тавих, саналыг холбогдох газарт уламжлан шийдвэрлүүлэх | - | Уламжилсан иргэдийн тоо | 415 | 150 | 300 | Төрийн дээд одон медалаар шагнуулахаар ирүүлсэн иргэдийн материалыг хүлээн авч шаардлага хангасан материалыг холбогдох газруудад албан бичгээр хүргүүлэн ажилласан. Ерөнхийлөгчийн Тамгын газарт тайлант хугацаанд нийт 595 иргэний материалыг албан бичгээр уламжлан хүргүүлж, able програмд бүртгүүлсэн. Ламын гэгээний 385 жилийн ойн баяраар 143 иргэний Төрийн дээд одон медаль болон салбарын шагналаар шагнагдсан. Аймгийн тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнуулахаар ирүүлсэн иргэдийн материалыг авч хэлэлцэн, аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/527 дугаар захирамжаар Аймгийн тэргүүний ажилтан цол тэмдгээр 14 иргэн, Засаг даргын Жуух бичгээр 17 иргэнийг шагнасныг баталгаажуулан олгосон. | 100% |
| 2.3 | Төрийн албан хаагчдыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | 220 сая | Тоног | 0 | 50 | 60 | Тоног төхөөрөмж нийлүүлэх тендер шалгаруулалтад “Буянт хөрс наран” ХХК шалгарч, орон нутгийн хөгжлийн | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|-----|---|-----------------------------|---|-----|-----|-----|---|------|
| | /ЗДТГ, ИТХ, Санхүүгийн хяналт дотоод аудит/ | ОНХС | төхөөрөмжийн хангалтын хувь | | | | санхүүжилтээр аймгийн Засаг даргын Тамгын газар, сумдын ИТХ, Засаг даргын тамгын газар, Санхүүгийн хяналт дотоод аудитын албанд 126 ширхэг тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. | 100% |
| 2.4 | Багийн Засаг дарга нарт шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах. | 132,32 сая ОНХС | Тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 0 | 50 | 70 | Орон нутгийн хөгжлийн сангийн 132.32 сая төгрөгийн санхүүжилтээр 95 багийн Засаг даргад нөүтбүүк, мотоцикл, 74 багийн даргад принтер олгосон. | 100% |
| 2.5 | Багийн Засаг дарга нарыг чадавхжуулах сургалт зохион байгуулах | Засаг даргын нөөц хөрөнгөөс | Мэдлэг чадвар нь 30 хувь дээшилсэн байна. | 125 | 130 | 135 | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 303 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд багийн Засаг дарга нарыг чадавхжуулах богино хугацааны сургалтыг зохион байгуулах ажлыг аймгийн Засаг даргын 2024 оны А/145 дугаар захирамжаар баталж, 2024 оны 03 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд Удирдлагын Академийн Удирдахуйн ухааны сургуулийн захирал, доктор проф. Б.Баясгалан, Доктор Г.Жаргал, Сургагч багш Ц.Үүрийнтуяа нартай хамтран зохион байгууллаа. Нийт 19 сумын 97 багийн Засаг дарга буюу 92.4 хувь нь идэвхтэй хамрагдаж Удирдлагын академийн богино хугацааны сургалтын гэрчилгээг гардан авлаа. Шилдгийн шидэг оролцогчоор Эрдэнэцогт сумын Ямаат 2 дугаар багийн Засаг дарга Д.Эрдэнэчулуун болон шилдэг сургагч багш, менежерээр ТЗУХ-ийн ахлах мэргэжилтэн Б.Наранцэцэг нар шалгарч, БНСУ-ын Нутгийн удирдлагын хөгжлийн институтэд (LOGODI) туршлага судлах сургалтад хамрагдсан. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|-----|--|---------------------|--|-----|-----|-----|---|------|
| 2.6 | Байгууллагын төлөвлөлт, системийн еoffice.baiahongor.gov.mп цахим ашиглалтыг сайжруулах, хяналт тавих бичиг хяналтын системийн еoffice.baiahongor.gov.mп цахим системийн ашиглалтыг сайжруулах, хяналт тавих | Байгууллагийн төсөв | Агентлаг, сум байгууллагын цахим системийн ашиглалтын хувиар | 0 | 45% | 55% | еoffice.baiahongor.gov.mп системээр захирамж, тушаалын төслүүд болон бусад албан бичгийг албан хаагчдаас хүлээн авч хэвлэн, бүртгэлийн дугаар олгон ажиллаж байна. | 100% |
| 2.7 | ISO 9001 менежментийн тогтолцоог нэвтрүүлэх | Байгууллагийн төсөв | Стандартын хэрэгжилтийн хувь | | 40% | 60% | ISO 9001 чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд 3 удаагийн зөвлөх үйлчилгээг авч, чанарын гарын авлага, бусад баримт бичгүүдийг боловсруулсан. Хэлтэс, албан хаагчдад ISO хавтас бүрдүүлэх, байгууллагын хэмжээнд мөрдөх журмууд, түүний хүрээнд хийгдэх ажлууд, хэлтсийн холбогдох баримт бичгүүдийг боловсруулж, байгууллага ISO чанарын менежментийн тогтолцооны баталгаажуулалт авсан. Энэ хүрээнд дотоод аудиторын сургалтад 6 албан хаагч 2024 оны 04 дүгээр сарын15-наас 18-ны өдрүүдэд хамрагдаж, дотоод аудитороор бэлтгэгдэж, сертификатаа авсан. ISO чанарын менежментийн тогтолцоог тасралтгүй хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна. | 100% |
| 3 | Зорилт 3. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах, батлуулах, сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавих зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 3.1 | Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах | - | Хэрэгжилтийн хувь | 80% | 40% | 40% | Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн 160 заалтыг 82,19 хувьтай нэгтгэн тайлагнасан. Жилийн эцсийн хэрэгжилт тайлангийн цаглаврын дагуу 12 дугаар сарын 30-нд тайлагнана. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|-----|--|---|-------------------|-----|-----|-----|---|------|
| 3.2 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах | - | Хэрэгжилтийн хувь | 80% | 40% | 40% | <p>хөтөлбөрийн эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжөөр өгсөн эрчимжүүлэх шаардлагатай, хэрэгжилт удаашралтай заалтуудыг хяналтад авч, төлөвлөгөө боловсруулж, Онцгой байдлын газарт зөвлөмж өгч ажилласан.</p> <p>Хууль тогтоомжийн хэрэгжилтийг сар бүр тайлагнаж 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилт 205 заалт 80,26 хувьтай, VII сарын хэрэгжилт 76,51 хувьтай, IX сарын хэрэгжилт 80,17 хувьтай, X сарын хэрэгжилт 85,21 хувийн хэрэгжилттэй тус тус тайлагнасан. Аймгийн Засаг даргаас сум, байгууллагын дарга нарт даалган гаргасан 256 захирамжийг хяналтад авч холбогдох хэлтэс агентлагуудад хүргүүлж ажилласан. 2024 оны эхний хагас жилийн нэгдсэн хэрэгжилт 89,94 хувьтай, III улирлын хэрэгжилт 83 хувийн хэрэгжилттэй тус тус тайлагнасан. Аймгийн хэмжээнд нийт захирамжийн хэрэгжилт агентлагуудын 2024 оны эхний хагас жилийн захирамжийн дундаж хэрэгжилт 87,85 хувь болж өмнө оны мөн үеэс 12,18 хувь, сумдын дундаж хэрэгжилт 64,24 хувь болж өмнө оны мөн үеэс 6,37 хувь, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын дундаж хэрэгжилт 78,55 хувь болж өмнө оны мөн үеэс 16,42 хувиар тус тус өссөн эерэг үзүүлэлтэй байна. Аймгийн Засаг даргаас сум, байгууллагын дарга нарт даалган гаргасан 256 захирамжийг хяналтад авч холбогдох хэлтэс агентлагуудад хүргүүлж ажилласан. 2024</p> | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|-----|---|---|-------------------|-------|-----|-----|--|------|
| 3.3 | Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах | - | Хэрэгжилтийн хувь | 92.5% | 45% | 50% | <p>оны эхний хагас жилийн нэгдсэн хэрэгжилт 89,94 хувьтай, III улирлын хэрэгжилт 83 хувийн хэрэгжилттэй тус тус тайлагнасан. Аймгийн хэмжээнд нийт захирамжийн хэрэгжилт агентлагуудын 2024 оны эхний хагас жилийн захирамжийн дундаж хэрэгжилт 87,85 хувь болж өмнө оны мөн үеэс 12,18 хувь, сумдын дундаж хэрэгжилт 64,24 хувь болж өмнө оны мөн үеэс 6,37 хувь, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын дундаж хэрэгжилт 78,55 хувь болж өмнө оны мөн үеэс 16,42 хувиар тус тус өссөн зэрэг үзүүлэлттэй байна.</p> | 100% |
| | | | | | | | <p>Бодлогын хэлтсүүдийн 2024 оны эхний хагас жилий үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн зөвлөмж, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын зөвлөмжийн мөрөөр хийх ажлын төлөвлөгөөг боловсруулж 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр хэлтсийн даргаар батлуулсан. Зөвлөмжид хэрэгжилт удаашралтай, эрчимжүүлэх шаардлагатай 8 ажил арга хэмжээг төлөвлөж, 2024 оны 3/1372 дугаар албан бичгээр зөвлөмжийн хэрэгжилт 67 хувьтай тайлагнасан. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн 2024 оны эхний хагас жилийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт тасалсан болон хоцорсон тайлан байхгүй үйл ажиллагааны хэрэгжилт 83,3 хувьтай үнэлэгдэж өмнө оны мөн үетэй хариуцуулахад 54,5 хувиар өссөн зэрэг үзүүлэлттэй байгаа нь Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн зөвлөмж, дүгнэлтээс харгалдаж байна. Мөн Хяналт шинжилгээ</p> | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|-----|---|---|-----------------------------|----|----|---|--|------|
| 3.4 | Сайдуудтай гэрээ байгуулах ажиллагаанд оролцох гэрээ үйл | | Гэрээ байгуулсан сайдын тоо | 18 | 18 | - | Үнэлгээний нийт зөвлөмжийн хэрэгжилтийг сум байгууллага бүр хяналтад авч хагас жилийн байдлаар 62,12 хувьтай тайлагнасан эерэг үзүүлэлттэй байна. Жилийн эцсийн хэрэгжилт хүлээгдэж байна. | 100% |
| 3.5 | Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах, сумдын Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээ байгуулах арга хэмжээг зохион байгуулах ажиллах | - | Байгууллагын тоо | 53 | 53 | - | Аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан Монгол Улсын Засгийн гишүүд, салбар яамны сайд нартай 2024 онд хамтран ажиллах гэрээг тус оны 02 дугаар сарын 03-ны өдөр байгуулсан. Шударга, ил тод, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлж, орон нутгийн удирдлагын бүх шатны байгууллагад ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгаж, хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хамтран ажиллах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, үр дүнг нь үнэлж дүгнэх, иргэдэд хүргэх, төрийн болон нийгмийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлж ажиллах зорилготойгоор тухайн гэрээг байгууллаа. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|----------|--|---|--|-----|-----|-----|--|------|
| | | | | | | | хяналт тавьж, 2024 онд 23 агентлагийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг бүрэн батлуулсан. Сумдын Засаг дарга нарын 2024 онд хамтран ажиллах гэрээний саналыг сум, агентлаг, бодлогын хэлтсүүдээс санал авч 141 заалт, 7 хавсралттай нэгтгэн боловсруулсан. Аймгийн Засаг дарга сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээг 20 сум бүрэн батлуулж нийт 53 байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хамтран ажиллах гэрээг баталсан. | |
| 4 | Зорилт 4. Төрийн үйлчилгээний соёл, хүртээмжийг дээшлүүлэх, мэдээ мэдээллээр хангах, иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, судалгаа шинжилгээ хийх зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 4.1 | Цаг үеийн шинж, чанартай үйл ажиллагаанд оролцох, зохион байгуулах | - | Үйл ажиллагааны тоо | 0 | 2 | 3 | "Алдарт эхийн одон гардуулах", Олон улсын ахмадын баяр, Шинээр томилогдож буй сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарыг чадавхжуулах сургалтыг тус тус зохион байгуулан ажилласан. | 100% |
| 4.2 | Иргэдээс төрийн албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх системийн ашиглалт, хэрэглээг нэмэгдүүлэх, хяналт тавих | - | Төрийн байгууллагын цөхмий системийн ашиглалтын хувиар | 55% | 58% | 60% | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл гомдлын мэдээллийг хагас жилийн байдлаар 240 өргөдөл ирүүлсэнээс 268 өргөдөл хугацаа болоогүй хүлээгдэж байна. Нийт 4581 өргөдлөөс 4045 өргөдлийг шийдвэрлэж, шийдвэрлэлтийн хувь 88,2 хувьтай байна. Жилийн эцсийн тайлан мэдээг сум, агентлагуудаас 12 дугаар сарын 25 -ний дотор хүлээж авч нэгтгэж Засгийн газарт 2025 оны 01 дүгээр сарын 05-нд хүргүүлнэ. | 100% |
| 4.3 | Аймгийн хэмжээнд зохион байгуулагдах хурал, зөвлөгөөний асуудлыг хариуцан зохион байгуулах, шийдвэрийн | | Аймгийн хэмжээнд зохион байгуулсан хурал, | 1 | 5 | 8 | Аймгийн "Удирдах ажилтны зөвлөгөөн"-д аймгийн удирдлагууд, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 24 агентлаг, төрийн болон орон нутгийн өмчит 10 байгууллага, 20 сумын ИТХ-ын дарга, нарийн бичгийн | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | |
|-----|--|---|------------------------|---|------|------|---|------|--|
| | хэрэгжилтийг хангуулах, хяналт тавьж, тайлагнах | | зөвлөгөөн ий тоо | | | | дарга, сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын дарга нар нийт 135 хүн оролцсон. Зөвлөгөөн 2024 оны 04 дүгээр сарын 1-2 өдрүүдэд Удирдах ажилтнуудад зориулсан сургалт, ТАЗ-ын ёс зүйн сахилга хариуцлагыг сайжруулах зэрэг агуулгаар зохион байгуулсан. 2023 оны нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн дүнг танилцуулж, 2024 онд хамтран ажиллах гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө баталж ажилласан. "Хөдөлмөрийн аварга", "Ламын Гэгээнд Бат Оршил Өргөх Баяр наадам, шашин соёл, ёслол хүндэтгэлийн арга хэмжээг тус тус зохион байгуулж ажилласан. | | |
| 4.4 | Аймгийн албан ёсны цахим сайтын ашиглалтыг сайжруулах, хөгжүүлэх, хяналт тавих | - | Сайтын хандалтын тоо | 0 | 2500 | 5000 | Аймгийн албан ёсны ayaaphongov.gov.mn цахим хуудасны хандалтын тоог нэмэгдүүлэх зорилгоор цахим хуудасны хэвийн жигд тасралтгүй үйл ажиллагааг ханган нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар байнга ил тод нээлттэй байлгах аргаар заасан 5 бүлгийн 46 заалтад хамаарах мэдээллийг хуульд заасан хугацаанд тогтмол шинэчилж ажилсан. Мөн Баянхонгор аймгийн алдартнууд цэс үүсгэн мэдээллийн | 100% | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | |
|-----|--|---|---|------|------|------|--|------|--|
| | | | | | | | <p>баяжуулалт хийв. Цахим хуудас хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор Хөдөө аж ахуйн их сургуулийн Баянхонгор аймаг дахь салбар сургууль, Политехникийн коллежийн 40 гаруй оюутнуудад baaahongog.gov.mn цахим хуудсыг танилцуулан "Цахим засаглал-Төрийн байгууллагын ил тод байдлыг сайжруулах нь" сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Энэ оны жилийн эцсийн байдлаар baaahongog.gov.mn цахим хуудсанд давхардсан тоогоор 5500 гаруй иргэн хандан мэдээлэл хүлээн авч, цахим хуудасны нийт хандалтын тоо 33030 буюу 2023 оны жилийн эцсээс 5846-аар өссөн үзүүлэлттэй байна.</p> | | |
| 4.5 | Нээлттэй мэдээллийг baaahongog.gov.mn цахим хуудсанд байнга ил тод, нээлттэй мэдээлэх | - | shilen.gov.mn системийн үнэлгээний хувиар | 100% | 100% | 100% | Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэн, нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар байнга ил тод, нээлттэй байлгах аар заасан мэдээллийг baaahongog.gov.mn цахим хуудсанд бүрэн байршуулж, шаардлагатай мэдээллийг хуульд заасан хугацаанд тогтмол шинэчлэн, өөрийн байгууллагын системийн бүрэн бүтэн байдал, мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг хариуцан ажиллаж, 2024 оны эхний хагас жилийн шилэн индексийн тайланг илгээж улсын хэмжээнд ил тод байдлын үнэлгээгээр топ 10 байгууллагын нэгдүгээрт эрэмбэлэгдсэн. Тухайн системээр тайлант оны жилийн эцсийн тайланг илгээж, 99.50 хувьтай үнэлэгдсэн. | 100% | |
| 4.6 | Агентлагуудын нээлттэй мэдээллийн ил тод | - | Хэрэгжилтийн | 43% | 60% | 80% | Агентлагуудын нээлттэй мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж хяналт | 100% | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|-----|---|---|---------------|-------|-----|-----|--|------|
| | байдлыг ханган ажиллаж буйд хяналт тавих, удирдлага арга зүйгээр хангах | | дундаж хувиар | | | | <p>тавих, удирдлага арга зүйгээр хангах ажлын хүрээнд:</p> <p>1.Хуулиар нээлттэй ил тод мэдээлэхээр заасан мэдээллүүдийг мэдээллийн самбар, цахим хуудас болон мэдээллийн бусад хэрэгсэл ашиглан нийтэд ил тод мэдээлж ажиллах чиглэлийг 2024 З/463 албан бичгээр өгсөн.</p> <p>2.Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэстэй хамтран "Ил тод байдлын шалгуур үзүүлэлт, түүнийг тайлагнах, үнэлэх журмын хэрэгжилт" сургалтыг зохион байгуулж, холбогдох 22 албан хаагч танхимаар хамрагдсан. Тус сургалтаар ил тод байдлын тухай хуулийн ерөнхий ойлголт, цаашид хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллах талаар зөвлөмж болон мэдээллийн ил тод байдлын тайланг зөв тайлагнах ойлголт арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.</p> <p>3.Аймгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын 2024 оны эхний хагас жилийн ил тод байдлын дундаж үнэлгээ 58.13 хувьтай байв. Үнэлгээний дүнг 2023 оны эхний хагас жилийн дүнтэй харьцуулахад агентлагуудын дундаж үнэлгээ 18.19 хувиар өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>4.Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэн 10 агентлаг хугацаанд нь 2024 оны жилийн эцсийн тайланг ирүүлж тайлагналтын ирц 55.5 хувьтай байна.</p> | 9 |
| 4.7 | Төрийн болон орон нутгийн өмчит | - | Хэрэгжилтийн | 17,7% | 30% | 60% | Аймгийн 10 төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын ил тод байдлыг | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | | | | | |
|-----|--|---|----------------------------|-------|-----|-----|---|------|--|--|--|--|--|
| | байгууллагуудын нээлттэй мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж буйд хяналт тавих, удирдлага арга зүйгээр хангах | | дундаж хувиар | | | | нэмэгдүүлэх зорилгоор: Хуулиар нээлттэй ил тод мэдээлэхээр заасан мэдээллүүдийг мэдээллийн самбар, цахим хуудас болон мэдээллийн бусад хэрэгсэл ашиглан нийтэд ил тод мэдээлж ажиллах чиглэлийг аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны 3/464 албан бичгээр чиглэл хүргүүлсэн. Мөн ил тод байдлын шалгуур үзүүлэлт, түүнийг тайлагнах, үнэлэх журмын хэрэгжилт сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдөр танхимаар зохион байгуулав. Сургалтад 6 төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын холбогдох албан хаагчдад нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, байнга ил тод, нээлттэй байршуулах мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбартаа бүрэн байршуулан ажиллах, тайланг шалгуур үзүүлэлтийн дагуу зөв тайлагнах ойлголт арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Төрийн болон орон нутгийн өмчит 9 байгууллагын холбогдох албан хаагчдад нээлттэй мэдээллийн "shilen.gov.mn" үнэлгээний нэгдсэн системд хандах эрхийг үүсгэн холбогдох мэдээлэл, зааварчилгаа өгч ажиллалаа. Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын ил тод байдлын үнэлгээ нь хангалтгүй байгаа нь 8 байгууллага албан ёсны цахим хуудас байхгүй байгаатай холбоотой байна. | | | | | | |
| 4.8 | Сумдын нээлттэй ил тод байдлыг ханган ажиллаж буйд хяналт тавих, | - | Хэрэгжилтийн дундаж хувиар | 34,3% | 50% | 70% | Сумдын нээлттэй мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж буйд хяналт тавих ажлын хүрээнд: | 100% | | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|--------------------------------------|---|---|---|---|---|--|---|
| | <p>удирдлага арга зүйгээр хангах</p> | | | | | | <p>1.Цахим хуудас хөтлөлтийн тайланг ирүүлэх талаар аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны 3/698 дугаартай албан бичиг хүргүүлсэн. Энэ хүрээнд тус тайланг Баянлиг, Бууцагаан, Галуут, Жаргалант, Шинэжинст сумууд ирүүлж зөвлөмж авч ажиллан ил тод байдлын үнэлгээг 7-21 оноогоор өсгөн ажилласан.</p> <p>2. Сумдын 2024 оны эхний хагас жилийн ил тод байдлын үнэлгээ 59 хувьтай үнэлэгдэж өмнө оны мөн үетэй харьцуулахад сумдын дундаж үнэлгээ 19.95 хувиар, өссөн эерэг үзүүлэлттэй байна.</p> <p>3.Нээлттэй мэдээллийн shien.gov.mn нэгдсэн системд 2.0 хувилбар нэвтэрсэнтэй холбогдуулан шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэн системд хандах эрхийг мэдээлэл хариуцагч 19 сумын Засаг даргын Тамгын газрын 23 албан хаагчид үүсгэн, систем ашиглалтын заавар, зөвлөгөөг өгч ажилласан.</p> <p>Удирдлага арга зүйгээр хангах ажлын хүрээнд:</p> <p>1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд байнга ил тод нээлттэй байлгахаар заасан мэдээллүүдийг мэдээллийн самбар, цахим хуудас болон мэдээллийн бусад хэрэгсэл ашиглан нийтэд ил тод мэдээлж ажиллах талаар аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны 3/462 албан бичгээр 20 сумын ЗДТГ-т чиглэл хүргүүлж ажилсан.</p> <p>2.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Терийн захиргааны удирдлагын хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс</p> | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|-----|---|---|--|-----|-----|-----|---|------|
| 4.9 | igden.baayanhongor.gov.mn системийн ашиглалт, хэрэглээг нэмэгдүүлэх | - | Цахим системийг хэрэглэж буй иргэдийн тоо нэмэгдсэн хувь | 25% | 55% | 60% | хамтран нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг зөв тайлагнах арга зүйг эзэмшүүлэх зорилгоор “Ил тод байдлын шалгуур үзүүлэлт, түүнийг тайлагнах, үнэлэх журмын хэрэгжилт” сургалтыг 20 сумын ЗДТГ-ын ил тод байдал хариуцсан мэргэжилтнүүдэд 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдөр цахимаар зохион байгуулсан. Сургалтад 18 сумын холбогдох мэргэжилтнүүд хамрагдаж сургалтын ирц 90 хувьтай байсан. 3..Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдийн 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн дагуу “Төрийн байгууллагын ил тод байдлыг нэмэгдүүлэх арга зүй” хялбаршуулсан гарын авлагыг боловсруулан шинээр томилогдсон сумдын ИТХ дарга, Засаг дарга нар болон холбогдох мэргэжилтнүүдэд хургуулж ажиллав. | 100% |
| | | | | | | | ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтоолцоог нэвтрүүлснээр төрийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэглэгчийн үнэлгээний судалгааг жилд 2 удаа авахаар төлөвлөсөн. Иргэдийн сэтгэл ханамжийн судалгаанд 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 3717 иргэн хамрагдсан бөгөөд судалгааны ажлын тайланг 2024 оны I, II дугаар улирлаар гарган, дүн шинжилгээ хийж нэгжийн даргаар баталгаажуулсан. Тайлант оны | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|------|--|---|---|---|------|------|--|------|
| 4.10 | Төрийн байгууллагын мэдээ мэдээллийг аймгийн албан ёсны байгууллагын бауанhongog.gov.mn вэбсайт болон олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах, мэдээлэх ажлыг зохион байгуулах | - | Иргэд олон нийтэд хүрсэн мэдээллийн тоо | 0 | 1000 | 2000 | жилийн эцсийн сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг 12 сард зохион байгуулахаар төлөвлөн хэлтсийн төлөвлөгөөнд тусгасан. Аймгийн Засаг дарга, ИТХ-ын дарга нарын хэрэгжүүлж буй бодлого шийдвэр, ажил арга хэмжээний талаарх мэдээллийг боловсруулах, түгээх, баримтжуулах ажлын хүрээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар "Нээлттэй засаг-Нэг Баянхонгор" фэйсбүүк пэйж хуудас болон албан ёсны бауанhongog.gov.mn цахим хуудсаар 3000 гаруй агуулга бүхий мэдээллийг боловсруулан нийтэлж, 5500 орчим минутын 300 агуулга төрөл бүхий видео бэлтгэж давхардсан тоогоор 660,000 гаруй мянган иргэдэд хүргэн ажиллалаа. Мөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар болон бусад холбогдох төрийн байгууллага, орон нутгийн үйл явдал, цаг үеийн мэдээ мэдээллийг бэлтгэх хүрээндээ 1.75 ТВ багтаамж бүхий 27,100 авч ширхэг фото зургийг баримтжуулав. | 100% |
| 4.11 | Аймаг орон нутгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил арга хэмжээг иргэд олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах | - | Иргэд олон нийтэд хүрсэн мэдээллийн тоо | 0 | 30 | 60 | Бүтээн байгуулалтын ажил арга хэмжээг сурталчлах ажлын хүрээнд 2024 оны 01 дүгээр сард "Ингэний сүүний үйлдвэр"-т эхний бүтээгдэхүүнээ үйлдвэрлэн гаргасан тухай мэдээ, 02 дугаар сараас эхлэн өнгөрсөн онд хийгдсэн бүтээн байгуулалтын ажил, 2024 оны хөрөнгө оруулалтаар хийгдэхээр төлөвлөгдсөн ажил, арга хэмжээний хэрэгжилтийн талаар 100 гаруй агуулга бүхий пост мэдээ, 20 минутын видео контент бэлтгэж албан ёсны бауанhongog.gov.mn цахим хуудас болон | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|------|---|---|--|-------|-----|-----|--|------|
| | | | | | | | мэдээллийн "Нээлтэй засаг-Нэг Баянхонгор" пэйж хуудсаар олон нийтэд хүргэсэн. | |
| 4.12 | Иргэдэд үйлчилгээний төвөөр үйлчилгээний хүртээмжийг тавих сайжруулах төрийн нэгдсэн үзүүлэх чанар нэмэгдүүлэх, хяналтыг хангалттай сайжруулах | - | Үйлчилгээний нэр төрөл, үйлчлүүлсэн иргэдийн тоог нэмэгдүүлсэн хувиар | 56585 | 30% | 85% | Үйлчилгээний нэгдсэн төвд үйлчилгээ үзүүлж буй Хөдөлмөр халамжийн үйлчилгээний баг хариуцсан мэргэжилтнүүд 22403 иргэнд үйлчилж, төрөөс иргэдэд үзүүлж буй 16,494,354,688 төгрөгийн халамжийг олгосон байна. Баянхонгор сумын баг хариуцсан газрын даамлууд 16259 иргэнд, Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн улсын бүртгэгч 1142 иргэнд, Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгчид нийт 116 холбогдогчдод өмгөөллийн үйлчилгээ болон зөвлөгөө мэдээллийг үзүүлсэн байна. Нотариатч 8207 иргэнд, E-Mongolia операторын үйлчилгээг хариуцсан мэргэжилтнүүд 32166 иргэнд төрийн үйлчилгээг давхардсан тоогоор нийт 80293 иргэнд хүргэсэн байна. | 100% |
| 4.13 | 70440001 дугаарын утсаар ирүүлсэн иргэдийн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч, холбогдох албан тушаалтнуудад танилцуулах, шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг хангуулах, иргэнд хариуг хүргүүлэх | - | Иргэний гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэж иргэнд тухай бүр хариуг мэдэгдэх | 12 | 70% | 85% | Аймгийн засаг даргад хандан 70440001 дугаарын утсанд 16 санал гомдол ирүүлснийг тухай бүрд нь бодлогын хэлтсийн удирдлага мэргэжилтнүүдэд шилжүүлэн 100 хувь шийдвэрлүүлж ажилласан байна. | 100% |
| 4.14 | Монгол улсын засгийн газрын 11-11 төвд иргэдээс ирсэн санал хүсэлт гомдлыг хүлээн авч, холбогдох | - | Иргэний гомдлыг түргэн шуурхай | 162 | 50% | 85% | Монгол Улсын Засгийн газрын 11-11 төвд тайлангийн хугацаанд 103 санал гомдлыг ирүүлсэн байна. Холбогдох хэлтсийн дарга, бодлогын мэргэжилтэнд шилжүүлэн | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|------|---|---|---|-----|-----|------|--|------|
| | албан тушаалтнуудад танилцуулж, шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг хангуулах | | шийдвэрлэж иргэнд тухай бүр хариуг мэдэгдэх | | | | шийдвэрлэлтийг цахим системд албан бичгээр хаалт хийж ажилласан. Хугацаа болоогүй, хүлээгдэж байгаа 10 санал, гомдол байна. | |
| 4.15 | Аймгийн Засаг даргын Тамгын газарт ирсэн баримт бичгийг зөв хаягласан, стандарт шаардлага бүрдэл бүрэн хангасан эсэхийг шалгаж, төвлөрсөн журмаар хүлээн авч, урьдчилан танилцах, ангилах, бүртгэх, цахим санд оруулах, удирдлагад танилцуулж, холбогдох ажилтанд шилжүүлэх, шийдвэрлэлтэд хяналт тавих | - | Хэрэгжилтийн хувь | 90% | 90% | 100% | Тайлант онд стандартын шаардлага бүрдэл бүрэн хангаж хаягласан 4270 албан бичиг хүлээн авч, дэвтрээр бүртгэн, Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын даргаар цохолт хийлгэн бодлогын хэлтсүүдэд хүргүүлж, албан бичгийг ERP програмд давхар бүртгэн, pdf файл үүсгэн ажиллаж байна. Мөн Төрийн захиргааны удирдлагын хэлтэст 500, Хууль эрх зүйн хэлтэст 816, Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэст 1250, Нийгмийн бодлогын хэлтэст 560, Санхүү төрийн сангийн хэлтэст 1400, Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст 318 албан бичиг ирснийг хүргүүлэн ажилласан. | 100% |
| 4.16 | Захирамж, Тушаал, Тогтоол, Хурлын тэмдэглэл, Гэрээ, Засаг даргын А/4, А/5, болон Тамгын газрын А/4, А/5 албан бичгүүдийг аймаг болон сумын хэмжээний байгууллагуудад егр системээр дамжуулан pdf файл үүсгэн цахимд шивж оруулсан байх | - | Хэрэгжилтийн хувь | 90% | 90% | 100% | Аймгийн Засаг даргын А захирамж 679, Б Захирамж 107, Засаг даргын албан даалгавар 8, Монгол Улсын Засгийн газар болон Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол 102, Засаг даргын Тамгын газрын даргын А тушаал 133, Б тушаал 150, Засаг дарга болон орлогчоос явуулсан албан тоот 910, Засаг даргын Тамгын газраас явуулсан албан тоот 1594, тус газраас аж ахуй нэгж байгууллагуудтай байгуулсан гэрээ 104, байгууллагын хурлын тэмдэглэл 25, хэлтсүүдээс явуулж байгаа илтгэх хуудас | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|------|---|---|------------------------------|-----|-----|------|--|------|
| 4.17 | Сумдын Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад ажил албан тушаалын хүрээнд үйлдэн гаргадаг баримтуудыг бүрэн, зөв, санал авах хадгалах хугацааг тогтоон ангилах, нэмэлт өөрчлөлт оруулах нэгтгэх, нягтлан шалгах комиссын хурлаар хэлэлцүүлэх, даргаар хянуулах, Төрийн архивын тасгийн дэргэдэх ББНЦАЗ комиссын хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжүүлэх, хяналт тавих | - | Хэрэгжилтийн хувь | 90% | 90% | 100% | Сумдын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад чиг үүргийн хүрээнд гардаг баримтуудыг бүрэн тусгаж, санал авах, хадгалах хугацааг тогтоон, Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулж ажилласан. | 100% |
| 4.18 | Байгууллагын 2021 оны байнга хадгалах баримтыг цаасан болон цахимаар Төрийн архивын тасаг график төлөвлөгөөний дагуу данс, бүртгэлийн хамт хүлээлгэх өгөх | - | Хүлээлгэн өгсөн баримтын тоо | 0 | 3 | 265 | Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны байнга хадгалах 273 баримтын 14015 хуудас баримтын нүүр, дотоод товъёог, баталгааны хуудсыг шивж, Төрийн архивын тасгийн цахим системд мэдээллийг оруулан, скайнер, фотошолоор хуудас бүрийг цэвэрлэх, холбох зэрэг 6 үе шат бүхий дамжлагаар цэвэрлэн, төрийн архивын ажилтанд эхний 100 баримтыг хянуулж, цахим архив үүсгэхэд бэлэн болсон. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|------|---|---|---|---|-----|------|---|------|
| | | | | | | | Төрийн архивын цахим санд шинэчлэл хийгдэж байгаатай холбогдуулан цахим архив үүсгэх ажил түр зогсоод байна. | |
| 4.19 | Хэлтсүүдээс архивын баримтыг хуваарийн дагуу байгууллагын архивд хүлээн авах | - | Баримтын тоо | 0 | 544 | 1032 | БНШ комиссын шийдвэрийн дагуу 2023 оны байнга хадгалах 1032 баримтыг 11 дүгээр сард албан хаагчдаас бүрэн хүлээн авсан. | 100% |
| 5 | Зорилт 5. Гадаад харилцааны бодлого төлөвлөх, үр дүнтэй зохион байгуулах зорилтын хүрээнд | | | | | | | |
| | | | | | | | -Хунан мужид зохион байгуулагдсан экологийн соёл иргэншил болон аялал жуулчлалын хөгжлийн нөөцийн тогтвортой хөгжлийн туршлагаас хуваалцах "Байгальд ээлтэй хөгжил" сэдэвт хуралд аймгийн ЗДТГ-ын Байгаль орчин уул уурхай, газрын асуудал хариуцсан мэргэжилтэн, Байгаль орчны газрын дарга нар оролцсон. Тухайн онд байгаль орчны салбарын албан хаагчдыг гадаадад туршлага судлуулах ажлыг өмнөх онуудаас илүү оролцоотой зохион байгуулсан. Сургалтаас сурсан мэдсэнээ хэрэгжүүлэхээр Баянхонгор аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр бусад бодлогын баримт бичгүүдэд байгаль орчин, ногоон байгууламж, цөлжилтийн эсрэг хэрэгжүүлэх саналуудаа тусгасан байна. Мөн Шинэжинст сумд Эрдэнэ монгол ХХК уурхайн нутаг дэвсгэртээ 1 га газарт цөлжилтийн эсрэг дөрвөлжин тариалалтын аргыг туршиж үзэхээр төсөв хөрөнгийг шийдүүлсэн байна. | |
| 5.1 | Хамтын ажиллагаатай улс орнуудтай олон талт уулзалт зохион байгуулж, сайн туршлагыг орон нутагт нэвтрүүлэх. | 40 сая Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Муж аймаг орон нутгийн хоорондын хэлэлцээрийн тоо | 4 | 5 | 6 | | 100% |
| | | | | | | | -Канад Улсын Бритиш Колумбиагийн их сургуулийн профессор, Лаурел сангийн Монгол дахь төслийн зохицуулагч, доктор Хью Парсонсоор ахлуулсан ажлын хэсэг | |

| | | | | | | | | |
|-----|--|---|-----------------------|-----|-----|-----|---|------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | | | | | | | <p>манай аймагт ажиллаж, айлчлалын үр дүнд Баянхонгор аймгийн аймгийн 20 суманд Канад улсын Лаурел сан, Эрдэнэ ресурс, Эрүүл мэндийн яамтай хамтран нүдний өвчний эрт илрүүлэг, нүдний эмгэгээс урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн мэдлэг, дадал олгох цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр болсон.</p> <p>Аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдөр БНСУ-ын J Eneгуу компанийн төлөөлөлтэй уулзаж, эрчим хүч, барилга байгууламж, хот байгуулалт, газрын харилцаа, орон сууц, нийтийн барилга байгууламжийн чиглэлээр хамтран ажиллахаар санамж бичиг байгуулсан.</p> <p>Япон Улсын эрдэмтэдтэй хамтран Монгол орны хөрс, цаг уурт тохирсон шингэн бордоог үйлдвэрлэхээр Баянхонгор аймгийн Өлзийт-ХАА МСҮТ- тэй хамтран судалгаа, үйлдвэрлэлийн туршилтын ажил эхэлсэн.</p> <p>-Ганьсу мужийн Ланжоу хотод БОГ болон сумдын 6 мэргэжилтэнцэлжилттэй тэмцэх чиглэлээр 9 дүгээр сард 20 хоногийн сургалтад хамрагдаж тухайн орон нутгийн цөлжилттэй тэмцсэн туршлага, ногоон байгууламжтай танилцсан.</p> <p>-Мөн өвлийн хүлэмжийн тариалалтын чиглэлээр Баянхонгор сумын 7 албан хаагч туршлага судлаад ирсэн.</p> | |
| 5.2 | Хөрш зэргэлдээ болон гуравдагч хөрш орнуудтай гадаад хамтын ажиллагааг | - | Хамтын ажиллагааны үр | 10% | 20% | 30% | | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|-----|--|---------------------------|---------------------------------|---|---|---|---|------|
| | хөгжүүлэх эрчимжүүлэх ажлыг | | дүнгийн хувь | | | | байгуулж, Баянхонгор аймгаас ажиллах хүч ажиллуулах, оюутан сургах асуудлаар санал гарган талууд зөвшилцөлд хүрэв. | 9 |
| 5.3 | Гадны улс, байгууллагатай байгуулсан гэрээ хэлэлцээр, хамтын ажиллагааны бичиг тусгагдсан ажил, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллах | - | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | 2 | 1 | 2 | -БНХАУ-ын Ниншя Хүй -ӨЗО-д "Цөлжилттэй тэмцэх арга аргачлал" танхим, практик хосолсон 7 хоногийн сургалтад байгаль орчны чиглэлийн 14 албан хаагчийг хамруулж, чадавхжуулсан. -БНХАУ-ын Гансу мужид 10 оюутныг инженерийн чиглэлээр элсүүлсэн. -ХААИС-ын Баянхонгор аймаг дахь салбар сургуулийн багш, ажилтан, оюутан 15 хүний баг Ганьсу мужийн Жичюань хотын коллежид туршлага судлаад ирсэн. -ЕБС-ийн 9 сурагчийг БНХАУ-д соёлын солилцооны хөтөлбөрт хамруулж, орон нутгийн соёлыг сурталчилж ажилласан. | 100% |
| 5.4 | Төрийн дээд албан тушаалтан, гадаадын зочид төлөөлөгчдийг угтах, үдэх, хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах | Засаг даргын нөөц хөрөнгө | Уулзалтын тоо | 0 | 2 | 3 | -Аймгийн ИТХ-ын дарга Э.Энхбат Унгар улсад хийсэн албан айлчлалын үеэр тус улсын Веспрем хотын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргатай байгуулсан гэрээний төсөлд Гадаад харилцааны яамны Олон улсын гэрэээрх зүйн газраас санал авч, тус айлчлалыг хийхэд арга зүйгээр хангаж ажиллав. -БНХАУ-ын ӨМӨЗО-ны Альшаа аймгийн Засаг даргын орлогч Бао Е тэргүүтэй төлөөлөгчид 2024 оны 11 дүгээр сарын 25-29-ний өдрүүдэд Монгол Улсад Баянхонгор аймагтай найрсаг хотын гэрээ байгуулах ажлаар албан айлчлал хийсэн. Төлөөлөгчдийг Улаанбаатар хотод хүлээн авах, байрлуулах, төлөвлөгөөт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, санамж бичиг байгуулах, үдэх ажлыг гүйцэтгэсэн. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|--------------------|-----------------------------------|---|----|----|--|------|
| Зорилт-6: Байгууллага, хэлтсийн дотоод үйл ажиллагааны талаар: | | | | | | | | |
| 6.1 | Байгууллагад шинээр томилогдсон хаагчийг дадлагажуулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, үр дүнг тооцох | | Хөтөлбөр ийн хэрэгжилт ийн хувиар | 1 | 50 | 90 | Байгууллагын "Шинэ ажилтныг дадлагажуулах хөтөлбөр"-ийг боловсруулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн А/105 дугаар тушаалаар батлуулсан. Хөтөлбөрийн үйл ажиллагаанд тайлант оны байдлаар шинээр томилогдсон нийт 5 алба хаагч хамрагдсан байна. | 100% |
| 6.2 | Иргэдийн дунд төрийн албан хаагчдад зориулж "ТАЛАРХЛЫН ЗАХИДАЛ"-ын илгээх аян зохион байгуулах | | Захидлын тоо | 8 | 8 | 10 | Байгууллагын ёс зүйн дэд хорооноос "Ёс зүйтэй төрийн албан хаагч" захидлын аяныг 11 дүгээр сард зохион байгуулсан. Тус арга хэмжээнд нийт 20 захидал ирснийг холбогдох холбогдох албан хаагчдад хүргүүлж ажилсан. Мөн "Төрийн албан хаагчид биендээ хэлэх үгс, Иргэдээс төрийн албан хаагчид хүргэх үг" сэдэвт аяныг 11 дүгээр сард өрнүүлж, төрийн албан хаагчдын үйл ажиллагааг ойлгож, тэднийг дэмжсэн 72 сэтгэгдэл ирсэн нь төрийн албаны үйл хэргийг иргэд ойлгож хүлээн авдаг болсон нь харагдаж байна. | 100% |
| 6.3 | Байгууллагын алба хаагчдын урьдчилан сэргийлэх үзлэг болон эрүүл, амьдралын хэвшил, дадалтай болгох нелееллийн арга хэмжээ зохион байгуулах | Байгууллагын төсөв | Албан хаагчдын тоо | 0 | 35 | 68 | "Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөн, "Эрүүл иргэн-Хонгорын баялаг" арга хэмжээг эрчимжүүлж "Бүжгээр эрүүлжье" аяны хүрээнд байгууллагын албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилсан сэргийлэх зорилгоор "Эрүүл мэндийн сорил", "Нарны алхалт", ажлын байрны идэвхитэй дасгал хөдөлгөөн, Эрүүл шүд-Эрүүл бие сэдэвт сургалтуудад байгууллагын албан хаагчдыг хамруулан ажилласан. Эдгээр арга хэмжээ нь албан | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|-----|--|-------------------------------|-------------|---|---|----|--|------|
| | | | | | | | хаагчдын эрүүл мэндээ анхаарахад нөлөөлж байна. | |
| 6.4 | Байгууллагын дотор, гадна камержуулалтыг сайжруулах, бүрэн ажиллагаанд оруулж, бичлэгийн нууцлалыг хамгаалах | Орон нутгийн хөгжлийн сан | Камерын тоо | | 0 | 16 | Аймгийн Засаг даргын Тамгын газрын дотор болон гадна нийт 18 камерыг шинээр суурилуулан, камерын хэвийн үйл ажиллагааг өдөр тутамдаа хянаж, бичлэгийн нууцлалыг хамгаалан ажиллаж байна. | 100% |
| 6.5 | Байгууллагын албан хаагчдын өрөө, танхимын хаяжилт, мэдээллийн самбарын ил тод байдлыг хангах | 1.276.0 Байгууллагын төсөв | Хаягийн тоо | | 0 | 42 | Аймгийн Засаг даргын Тамгын газрын 43 өрөөний 72 алба хаагчийн хаягийг 100% шинэчлэн сольсон, чимээгүй хөтчийг 1, 2, 3 дугаар давхарт байрлуулсан. Байгууллагын ил тод байдлын мэдээллийн самбарыг бүрэн хариуцаж шинээр батлагдсан эрх зүйн акт, статистик мэдээ, үйл ажиллагааны тайлан, үзүүлэх үйлчилгээ, тусгай зөвшөөрөл, гадаад харилцаа, хүний нөөц, архив, бичиг хэрэгтэй холбоотой мэдээллийг тухай бүр шинэчилж, тайлант оны хугацаанд давхардсан тоогоор 150 мэдээллийг сольж байршуулсан. | 100% |

ХЯНАСАН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Д.ЭНХЖАРГАЛ

ТАЙЛАН ГАРГАСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА *П. Отгонбаяр* - П.ОТГОНБАЯР

24

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА
ПҮРЭВИЙН ОТГОНБАЯРЫН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Аймгийн Засаг даргын Тамгын газар

Нэгжийн нэр: Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт (70 оноо) |
|-----|--|---------------------|-------------------|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | 99,3% | 69,5 |

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|--|---|--------------------------------|--|
| 1. | ISO Чанарын менежментийн тогтолцооны дотоод аудитор бэлтгэх сургалтад хамрагдах | 100% | 15 |
| 2. | Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газарт туршлага судлах | 100% | 15 |
| 3. | Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүр зохион байгуулдаг 7:4:10 сургалтад хамрагдах | 100% | 15 |
| Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо | | | |

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ


| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|--------------------------|--|
| 1. | Хандлага, ёс зүй | 15 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 15 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 15 |
| 4. | Манлайлах | 15 |
| 5. | Багаар ажиллах | 15 |
| 6. | Харилцаа | 15 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 2. | |
| 9. | Мэргэжлийн ур чадвар 3. | |
| Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо | | 15 |

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|--|---|--------------------------|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт) | 70 хүртэлх оноо 69,5 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ) | 15 хүртэлх оноо 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ) | 15 хүртэлх оноо 15 |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих) | оноо |
| Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 99,5 |

Үнэлгээ өгсөн:

Засаг даргын Тамгын газрын
Дарга
(албан тушаал)
нэр)



(гарын үсэг)

/Д.Энхжаргал/
(албан хаагчийн

2024.12.18

(огноо)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
Дарга
(албан тушаал)

Нэгжийн дарга:

(гарын үсэг)

/П.Отгонбаяр /
(албан хаагчийн нэр)

2024.12.18


(огноо)

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН
БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО**

2024 оны 12 дугаар сарын 05

Номгон

| Хяналтад авсан зүйл, заалтын тоо: 44 | | Номгон |
|--------------------------------------|------|-------------------------|
| Бүрэн хэрэгжсэн | 100% | 43 |
| Тодорхой үр дүнд хүрсэн | 90% | - |
| Тодорхой үр дүнд хүрсэн | 80% | - |
| Хэрэгжих шатанд | 70% | 1 |
| Хэрэгжилт хангалтгүй | 30% | - |
| Хэрэгжээгүй | 0% | - |
| Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй | | - |
| Хэлтсийн төлөвлөгөөний биелэлт | | Хэрэгжилтийн хувь 99,3% |



ХЯНАСАН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Д.ЭНХЖАРГАЛ
2024.12.18

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА П.ОТГОНБАЯР